



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/588

Зуунмод

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан шилжих үлдэгдлийн эх үүсвэрээс хэрэгжүүлэх “Сум, төсөвт байгууллагуудын автомашины парк шинэчлэлд орон нутгийн оролцоо (10 автомашин) төсөл, арга хэмжээнээс хавсралтад дурдагдсан Аргалант, Цээл сумдын автомашины худалдан авах ажиллагааг зохион байгуулах, захиалагчийн эрхийг холбогдох сумдын Засаг дарга нарт шилжүүлсүгэй.

2. Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, тендерийн урилга, төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил, үр дүн, гэрээ, ажил хүлээж авсан актыг тухай бүр цахим системд нийтэлж байхыг сумын Засаг дарга, захиалагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4174011198

Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр
сарын 27 -ны өдрийн А/588 дүгээр
захирамжийн хавсралт



ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөв /аймаг/	Сумаас нэмэгдсэн төсөв	Нийт өртөг /төгрөг/	Захиалагч байгууллага
1	Сум, төсөвт байгууллагуудын автомашины парк шинэчлэлд орон нутгийн оролцоо /Аргалант сум/	90,000,000	-	90,000,000	Аргалант сумын Засаг дарга
2	Сум, төсөвт байгууллагуудын автомашины парк шинэчлэлд орон нутгийн оролцоо /Цээл сум/	90,000,000	-	90,000,000	Цээл сумын Засаг дарга
	ДҮН	180,000,000	-	180,000,000	

_____оОо_____